



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/15/СТА-ТТЗ

<p>Хаяг: Архангай аймаг, Эрдэнэбулган сум. Аймгийн ЗДТГ-ын байр “А” корпус, 3 давхар зүүн жигүүр.</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр</p> <p>Утас: 70333141 Цахим хаяг: UlambayrD@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Байгалмаа</p> <p>Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn</p> <p>Аудитор: В.Цогжаргал</p> <p>Утас: Цахим хаяг: TsogjargalB@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/15/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.5.3 Авлага.....	12
3.5.6 Бараа материал.....	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.5.10 Орлогын данс.....	14
3.5.11 Зардлын данс.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	19
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	21
4. Менежментийн захидал.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



ИХТАМИР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ЦЭВЭЭНДОРЖ ТАНАА

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021.03.25 № 128

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Ихтамир сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ихтамир сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 76 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч нь нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	723,626.1	1,488,989.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	189,982.9	852,673.5
33	АВЛАГА	438,437.9	476,937.9
35	БАРАА МАТЕРИАЛ	95,205.3	159,378.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,874,519.4	6,200,211.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,874,519.4	6,200,211.8
39200	Биет хөрөнгө	5,739,521.9	6,065,478.5
39300	Биет бус хөрөнгө	134,997.5	134,733.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,598,145.5	7,689,201.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,598,145.5	7,689,201.4
51	Засгийн газрын хувь оролцоо	6,598,145.5	7,689,201.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,854,626.7	1,854,626.7
51200	Хуримтлагдсан үр дүн	1,330,552.8	2,423,784.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,412,966.1	3,410,789.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,598,145.5	7,689,201.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,294,234.9	4,235,163.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	140,261.3	872,854.3
110	Орлогын албан татвар	67,518.2	101,340.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	67,518.2	100,860.9
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	480.0
113	Хөрөнгийн албан татвар	3,480.1	4,550.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,263.0	766,963.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	291,551.5	694,070.5
120	Нийтлэг татварын бус орлого	291,551.5	694,070.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,862,422.0	2,668,238.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,087,620.7	2,987,831.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,087,620.7	2,987,831.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,623,908.2	2,878,810.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,689,344.4	1,887,948.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	211,245.0	254,816.2

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,841.0	154,268.4
2104	Хангамж, бараа материалын зардал	86,450.5	85,097.2
2105	Нормативт зардал	145,798.9	145,268.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,568.3	27,133.7
2107	Томилолт, зочны зардал	8,710.8	3,544.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,410.2	33,497.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	294,539.2	287,235.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463,712.5	109,021.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	206,614.2	1,247,331.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	61,578.8	156,275.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	145,035.3	1,091,055.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,175,526.6	3,653,046.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	140,261.3	872,854.3
110	Орлогын албан татвар	67,518.2	101,340.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	67,518.2	100,860.9
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	480.0
113	Хөрөнгийн албан татвар	3,480.1	4,550.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,263.0	766,963.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,949.2	15,218.5
1181	Газрын төлбөр	12,141.9	3,167.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	37,171.9	748,577.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	172,843.2	111,954.0
120	Нийтлэг татварын бус орлого	172,843.2	111,954.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,862,422.0	2,668,238.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,869,230.7	2,727,503.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,869,230.7	2,727,503.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,405,508.6	2,618,506.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,689,344.4	1,887,948.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	211,245.0	254,816.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,624.6	161,884.8
2104	Хангамж, бараа материалын зардал	82,546.8	75,241.9
2105	Нормативт зардал	159,487.5	104,586.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,021.4	28,848.4
2107	Томилолт, зочны зардал	8,710.8	3,544.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,094.7	38,256.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,433.4	63,380.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463,722.1	108,997.4

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	306,295.9	925,542.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	90,846.9	184,352.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,846.9	184,352.0
2200	Дотоод эх үүсвэрээр	90,846.9	184,352.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(90846.9)	(184352.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(83000.0)	(78500.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	83,000.0	78,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	132,449.0	662,690.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,534.0	189,982.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189,982.9	852,673.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,453,110.2	6,453,110.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	16,199.2	16,199.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,469,309.4	6,469,309.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(16,199.2)	(16,199.2)
9	Тайлант үеийн үр дүн	145,035.3	145,035.3
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,598,145.5	6,598,145.5
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,598,145.5	6,598,145.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,176.2	2,176.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,600,321.7	6,600,321.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,176.2)	(2,176.2)
19	Тайлант үеийн үр дүн	1,091,055.8	1,091,055.8
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,689,201.4	7,689,201.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,086,481.30	2,908,221.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,757,138.50	2,671,532.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,692,625.10	2,617,775.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,894,946.60	1,885,071.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,102.90	254,816.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,130.60	161,884.80
2104	Хангамж, бараа материалын зардал	73,999.60	72,123.50
2105	Нормативт зардал	144,470.30	101,124.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,626.00	36,658.20
2107	Томилолт, зочны зардал	4,519.50	3,544.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,244.50	40,937.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,585.10	61,615.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,513.40	53,757.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,513.40	53,757.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	204,342.80	158,189.50
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	125,000.00	78,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,086,481.30	2,794,191.20
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,951,491.70	1,888,845.40
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	759,418.80	770,289.40
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,500.00	56,853.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	314,070.80	78,203.40
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	142,262.60
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	28,231.90
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	173.5	173.5
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1043	1043
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	632	632
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	411	411
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	173.5	173.5

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,894.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,894.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,894.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,877.40
2104	Хангамж, бараа материалын зардал	4,138.80
2105	Нормативт зардал	3,462.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,330.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,085.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,894.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,894.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Б.Цэвээндорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн орон нутгийн ерөнхий орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, сум хөгжүүлэх сангийн авлагыг бууруулахад тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор В.Цогжаргал гүйцэтгэв.

Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны зорилго нь Нутгийнхаа байгаль орчинг хамгаалан, хүний ба бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг жигд хөгжүүлсэн, нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх сум болох” зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Ажлын байрыг 2-3 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- ✓ Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Ихтамир сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

Ихтамир сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,180,956.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 31,809.6 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 189,982.9 мянга, эцсийн үлдэгдэл 852,673.5 мянган төгрөг болж 662,690.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Төрийн сангийн харилцах	189,982.9	852,673.5	662,690.6
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	189,982.9	852,673.5	662,690.6
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	37,734.9	2,078.5	(35,656.4)
Орон нутгийн ерөнхий орлого	47,720.3	824,441.7	776,721.4
Орон нутгийн хөгжлийн сан	104,527.7	26,153.3	(78,374.4)
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	189,982.9	852,673.5	662,690.6

Эх сурвалж: Ихтамир сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 662,690.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн 3 арга арга хэмжээ дутуу хэрэгжиж, ундны усны ухаалаг төхөөрөмж суурилуулах ажил огт хэрэгжээгүйгээс 26,153.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, мөн сум хөгжүүлэх сан 2,078.6 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын данс 824,441.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл нь давсан орлого 787,633.8 мянга, орон нутгийн удирдлагын байгууллагын төвлөрүүлэх шилжүүлэг 36,807.9 мянган төгрөгөөс бүрдэж байна. Нийт давсан орлогын 91.7% буюу 722,100.0 мянган төгрөг нь байгалийн ургамал ашигласны төлбөр буюу самрын орлого байна.

3.5.3 Авлага

Авлагын данс 476,937.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Сум хөгжүүлэх сангаас 41 төсөл хэрэгжүүлэгчдэд олгосон зээлийн авлага байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 95,205.3 мянга, эцсийн үлдэгдэл 159,378.1 мянган төгрөг болж, 64,172.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	38,583.0	76,034.3	37,451.3
Эм боох материал	2,481.6	10,042.4	7,560.8
Бэлэн бүтээгдэхүүн	24.0	0.0	(24.0)
Бичиг хэргийн материал	5,112.2	9,543.8	4,431.6
Аж ахуйн материал	38,952.3	48,167.3	9,215.0
Түлш шатах тослох материал	2,715.3	8,186.1	5,470.7
Барилгын засварын материал	174.8	1,115.5	940.8
Хүнсний материал	2,562.1	2,078.6	(483.5)
Бусад хангамжийн материал	180.0	180.0	0.0
Мал амьтад	4,420.0	4,030.0	(390.0)
Дүн	95,205.3	159,378.0	64,172.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Засаг даргын тамгын газаро	12,481.0	12,481.0	0.0
Ерөнхий боловсролын сургууль	51,130.6	107,245.2	56,114.6
Эрүүл мэндийн төв	9,572.5	13,164.4	3,591.9
Соёлын төв	30.0	0.0	(30.0)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	252.0	252.0	0.0
Хүүхдийн цэцэрлэг	21,739.2	26,235.4	4,496.2
Дүн	95,205.3	159,378.0	64,172.7

Эх сурвалж: Ихтамир сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл нь ЕБС-ийн сумын төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтаар хангадагтай холбоотой тайлант оны эцэст 7,000.0 мянган төгрөгийн нүүрс нөөцөлсөн, мөн 40,546.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, ЭМТ нь 18,680.6 мянган төгрөгийн эм боох материалыг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой өсч тайлагнагдсан байна.

Бараа материал дансанд ЕБС-ийн 4,030.0 мянган төгрөгийн өртөгтэй 64 толгой мал бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

- Ихтамир сумын ЭМТ- 8,887.4 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг бараа материалын тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулан санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгүүлсэн.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,874,519.4 мянга, эцсийн үлдэгдэл 6,200,211.8 мянган төгрөг болж, 325,692.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,739,521.9	6,065,478.5	325,956.6
Биет бус хөрөнгө	134,997.5	134,733.3	(264.2)
Дүн	5,874,519.4	6,200,211.8	325,692.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Засаг даргын тамгын газар	1,485,450.8	1,789,490.2	304,039.4
Ерөнхий боловсролын сургууль	2,598,366.6	2,511,669.4	(86,697.2)
Эрүүл мэндийн төв	358,796.7	469,822.3	111,025.6
Соёлын төв	587,761.4	587,350.3	(411.1)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4,877.3	19,308.5	14,431.2
Хүүхдийн цэцэрлэг	839,266.6	822,571.1	(16,695.5)
Дүн	5,874,519.4	6,200,211.8	325,692.4

Эх сурвалж: Ихтамир сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 31,162.5 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 528,383.0 төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 33,309.3 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Үнэ төлбөргүй хандиваар авсан үндсэн хөрөнгийг эх үүсвэрээр задалвал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №4 Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө /мян. төгрөг/

№	Байгууллагын нэр	Эх үүсвэр			Нийт дүн
		Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Төсөл хөтөлбөр	
1	ЗДТГ	42,006.4	182,446.6	90,215.9	314,668.9
2	ИТХ	11,639.1			11,639.1
3	ЕБС	20,993.3	7,354.1		28,347.4
4	Хүүхдийн цэцэрлэг	8,504.7	10,479.3		18,984.0
5	Эрүүл мэндийн төв	145,584.6	4,970.0		150,554.6
6	Соёлын төв		4,189.0		4,189.0
Нийт дүн		228,728.1	209,439.0	90,215.9	528,383.0

Тайлант онд орон нутгийн төсөвт байгууллагууд улсын төсвөөс 228,728.1 мянга, орон нутгийн төсвөөс 209,439.0 мянга, төсөл хөтөлбөрөөс 90,215.9 мянга нийт 528,383.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээл авсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Ихтамир сумын ЕБС-БШУС-ын 2017 оны 40 дүгээр тушаалаар баталсан харьяа байгууллагуудад ашиглагдах НБББББ-ын баримт бичгийн 2 дугаар хавсралтаар баталсан үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоход баримтлах хугацааг хөрөнгийн материал, шинж чанараар нь харилцан адилгүй тогтоосон байхад сургуулийн бүх тавилга, эд хогшлыг 10 жилээр, техник тоног төхөөрөмжийг 5 жилээр элэгдэл тооцох хугацааг тогтоосон байна.
- Ихтамир сумын ЭМТ- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 64 нэр төрлийн нийт 50,124.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна зэрэг үнлсэн хөрөнгөтэй холбоотой зөрчилд аудитаас менежмент захидлаар зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.
- Ихтамир сумын ЗДТГ- 22,893.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулан санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгүүлсэн.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,598,145.5 мянга, эцсийн үлдэгдэл 7,689,201.3 мянган төгрөг болж, 1,091,055.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Засгийн газрын хувь оролцоо /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	1,854,626.7	1,854,626.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,330,552.7	2,423,784.8	1,093,232.0
Өмнөх үеийн үр дүн	1,185,517.4	1,332,729.0	147,211.6
Тайлант үеийн үр дүн	145,035.3	1,091,055.8	946,020.5
Хөрөнгийн дахин үнэлгээний	3,412,966.1	3,410,789.8	(2,176.2)
Дүн	6,598,145.5	7,689,201.3	1,091,055.8

Эх сурвалж: Ихтамир сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 1,091,055.8 мянган төгрөгөөр өсч тайлагнагдсан байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 872,854.3 мянган төгрөгийн татварын орлого, 694,070.5 мянган төгрөгийн татварын бус орлого, 2,668,238.2 мянган төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 4,235,163.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна. Тусламж санхүүжилтийн орлогын 1,944,085.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 26,894.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 640,405.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, эрүүл мэндийн даатгалын сангаас 56,853.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

3.5.11 Зардлын данс

Санхүүгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны зардал 2,987,831.5 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 156,275.7 мянган төгрөг, нийт 3,144,107.1 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна. Үйл ажиллагааны нийт үр дүн өмнөх оноос 946,020.5 мянган төгрөгөөр өссөн нь татварын болон татварын бус орлого өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд 516,941.2 мянган төгрөгийн давхардсан гүйлгээг устгах бичилт хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Ихтамир сумын ЗДТГ-Засаг даргын нөөц сангаас 18 захирамжийн дагуу 21,041.8 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд төлөвлөх боломжтой баяр наадмын зардалд 2020.07.07-ны А/72 тоот захирамжаар 1,140.0 мянган төгрөг, жилийн эцсийн мал тооллогын зардалд 2020.12.16-ны А/127 тоот захирамжаар 2,448.6 мянган төгрөг нийт 3,588.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.
- Ихтамир сумын Соёлын төв- ХХОАТ-ын 173.3 мянган төгрөг суутгаагүй, гэрэл цахилгааны зардлаас зохицуулалт хийлгүй 1080.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан зэрэг нийт 1253.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.
- Ихтамир сумын ЭМТ- 15,846.2 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудсаар хэтрэлт хэмнэлт тооцоогүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хөнгөлөлт тооцох хэмжээг зарим албан хаагчдын цалингаас зөрүүтэй тооцсон зэрэг зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Ихтамир сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны орон нутгийн ерөнхий орлогыг 87,110.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн орлогын төсвийн төслийг Сумын ИТХ-ийн 2019 оны 12 сарын 13-ны өдрийн 07 тоот тогтоолоор 23,602.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 110,713.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 119,013.1 мянган төгрөгөөр тодотгон баталж, гүйцэтгэлээр 906,846.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлж, төлөвлөгөөг 762.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Төвлөрүүлэх орлого /мян.төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	4,500.00	5,828.80	1,328.80	129.5
2	Шууд бус орлого	24,790.00	52,910.90	28,120.90	213.4
3	Хадгаламжийн хүүгийн орлого	20,400.00	38,640.00	18,240.00	189.4

4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150	3961.2	3,811.20	2,640.8
5	Бууны татварын орлого	5,820.00	4,550.00	(1,270.00)	78.2
6	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	3,880.00	2,412.40	(1,467.60)	62.2
7	Газрын төлбөр	0.00	174.10	174.10	100.0
8	Газрын дуудлага худалдааны орлого	3,300.00	2,993.10	(306.90)	90.7
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,380.00	1,010.00	(370.00)	73.2
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	14,250.00	11,796.00	(2,454.00)	82.8
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	96.00	722100.00	722,004.00	752,187.5
12	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	0.00	742.7	742.70	100.0
13	Ойн нөөц ашигласны төлбөр	31,397.10	25,685.10	(5,712.00)	81.8
14	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	50.00	50.00	0.00	100.0
15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	200.00	242.00	42.00	121.0
16	Хүү торгуулийн орлого	8500.00	33,650.60	25,150.60	395.9
17	Нэр заагдаагүй бусад орлого	500.00	100.00	(400.00)	20.0
Дүн		119,213.10	906,846.90	787,633.80	0.00

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч дараах 7 нэр төрлийн орлого 11,980.5 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Зарим галт зэвсэг эзэмшигч тодорхойгүй, иргэд хоорондоо худалдах, шилжүүлэх, ашиглах боломжгүй болсон зэрэг шалтгаанаар шинэчилсэн бүртгэл хийгдээгүйтэй холбоотой бууны татварын орлого 1,270.0 мянган төгрөгөөр
2. Мал эмнэлэгийн үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд аймгийн татварын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу үнэт цаас ашигласны тэмдэгтийн хураамжийг төлөөгүйтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,467.6 мянган төгрөгөөр
3. 3 байршилд дуудлага худалдаа зохион байгуулж газар эзэмшүүлэхээр төлөвлөсөн боловч 1 байршлын дуудлага худалдаанд оролцогч байхгүй байсны улмаас газрын дуудлага худалдааны орлого 306.9 мянган төгрөгөөр
4. Ар эрэгт байрлах элс, хайрга ашиглагч иргэд татвараа төлөөгүйн улмаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 370.0 мянган төгрөгөөр,
5. Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь түр зогссон ААН, байгууллагууд ажиллаагүй хугацааны хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөөгүйтэй холбоотой хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2,454.0 мянган төгрөгөөр,
6. Ковид-19 цар тахлын улмаас мод бэлтгэлийн ААН-үүдийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой ойн нөөц ашигласны төлбөр 5,712.0 мянган төгрөгөөр,
7. Нэр заагдаагүй бусад орлогод албан хаагчдын сахилгын шийтгэлийн торгуулийг оруулахаар төлөвлөсөн бөгөөд орлого 400.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. ИТХ-ын тогтоол /мян.төгрөг/

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	110,513.00	119,013.10	8,500.10
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	161,822.80	161,822.80	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	370,123.90	350,207.80	(19,916.10)
4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	78,672.20	74,815.10	(3,857.10)
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	2,434,834.80	2,268,497.30	(166,337.50)
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	32,358.40	47,720.30	15,361.90
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	104,527.70	104,527.70	-
Нийт дүн		3,292,852.80	3,126,604.10	(166,248.70)
Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	72,716.90	72,716.90	-
2	Засаг даргын тамгын газар	440,478.40	444,424.30	3,945.90
3	Орон нутгийн хөгжлийн сан	183,199.90	179,342.80	(3,857.10)
4	Сум хөгжүүлэх сан	128,000.00	128,000.00	-
5	Сургуулийн өмнөх боловсрол	497,977.60	451,557.20	(46,420.40)
6	Ерөнхий боловсролын сургууль	1,394,034.60	1,275,271.80	(118,762.80)
7	Соёлын төв	84,145.00	84,145.00	00.00
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	492,300.40	491,146.10	(1,154.30)
Нийт дүн		3,292,852.80	3,126,604.10	(166,248.70)

Ноос ноолуур, арьс ширний урамшууллаас орсон орлогын гүйцэтгэлд үндэслэн шууд бус орлогыг нэмж баталсанаас ерөнхий орлогыг 8,500.1 мянга, мөн урьд оны үлдэгдлийг 15,361.9 мянган төгрөгөөр нэмж тодотгосон бол орон нутгийн удирдлагын байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 19,916.1 мянга, сумын ОНХС-аас хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлд үндэслэн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 3,857.1 мянга, ковид-19 цар тахалтай холбоотой боловсролын байгууллагын үдийн цай хоолны зардал, ЭМТ-ийн тогтмол зардлаас 166,337.5 мянган төгрөгийг хасаж тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС-ийн нийт зардлыг 40,122.8 мянган төгрөгөөр бууруулж 1,235,149.0 мянган төгрөгөөр баталж сумын нийт зардлыг 3,086,481.3 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас хэмнэгдэж байгаа сургуулийн хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,086,481.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,757,138.5 мянган төгрөгийг урсгал АРА-2021/15/СТА-ТТЗ

зардалд, 204,342.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 125,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,951,491.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 759,418.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 61,500.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 161,822.8 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 152,248.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 43,887.3 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 85,812.7 мянган төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 34,316.1 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2,193.3 мянган төгрөгөөр давсан нь халаалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,908,221.9 мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь урсгал зардал 85,606.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, хөрөнгийн зардал 46,153.3 мянган төгрөг зарцуулагдаагүй, 46,500.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөсөн хэмжээнээс дутуу олгосонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 23,720.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,173.1 мянган төгрөг нийт 26,894.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж урсгал зардалд зарцуулсан байна.

ОНХС болон СХС-ийн талаар

- ✓ Сумын ИТХ-ын хурлын 2020 оны 09 сарын 28-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 13 хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 179,342.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.
Гүйцэтгэлээр 10 төсөл арга хэмжээ бүрэн, 3 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжиж, ундны усны ухаалаг төхөөрөмж суурилуулах ажил огт хэрэгжээгүйгээс нийт 26,153.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 128,000.0 мянга, олгох зээлийг 125,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 40,000.0 мянган төгрөгийн үндсэн зээл, 3,480.0 мянган төгрөгийн хүүгийн орлого төвлөрч, 78,500.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.
Нийт авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 228,182.9 мянган төгрөг буюу 47.8 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 245,275.0 мянган төгрөг буюу 51.4 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 3,480.0 мянган төгрөг буюу 0.8 хувь нь чанаргүй зээл байна.

Аудитаас 248,755.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 130 мэдээллээс 54 мэдээллийг хугацаанд нь, 76 мэдээллийг хугацаа хоцроож, 40,000.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

- Тайлант онд ОНХС-ийн 40,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хогны машин худалдан авсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй зөрчилд аудитаас албан шаардлага хүргүүлээ.

Засаг дарга дансны болон орон нутгийн хөгжлийн сангийн шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон ЗДТГ-ын нягтлан бодогч Т.Отгонжаргалд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 21,850.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 121,076.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	3	21,850.8	2	18,387.8	1	3,463.0	84.2
Зөвлөмж	1	121,076.9					50.0
Нийт	4	142,927.7	2	78,926.3	1	3,463.0	67.1

Өмнөх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 8 нэр төрлийн орлого тасарсаны 4 нэр төрлийн орлого нь энэ онд мөн тасарсан тул албан шаардлагын биелэлтийг 84.2 хувь, СХС-ийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч энэ жил хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 127,678.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа тул биелэлтийг 50 хувьтай байна гэж үзлээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9. Санал дүгнэлтийн хэлбэр

№	Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Засаг даргын тамгын газар	1			
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1			
3	Ерөнхий боловсролын сургууль	1			

4	Хүүхдийн цэцэрлэг			1
5	Эрүүл мэндийн төв	1		
6	Соёлын төв		1	
7	Орон нутгийн хөгжлийн сан		1	
8	Сум хөгжүүлэх сан		1	
	Дүн	4	3	1

Аудитаас дээрх 4 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 393,716.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 31,780.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 47,209.9 мянган төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 314,725.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүллээ. Үүнийг төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчаар ангилан харуулбал:

Нэг. Төсвийн шууд захирагчдын СТА-ын дүнгийн талаар

Төсвийн шууд захирагчдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 103,321.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 31,780.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 65,970.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 5,569.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 10. ТШЗ-ийн зөрчлийн нэгтгэл /мян.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс:				Залруулсан
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Засаг даргын Тамгын газар	4	26,481.7	1	0.0	2	3,588.6	22,893.1
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	0.0	1	0.0	1	0.0	
3	Ерөнхий боловсролын сургууль	2	0.0	1	0.0	1	0.0	
4	Соёлын төв	2	1,981.3			2	1,981.3	
5	Эрүүл мэндийн төв	6	74,858.3	4	65,970.9	1	0.0	8,887.4
	ДҮН	16	103,321.3	7	65,970.9	7	5,569.9	31,780.5

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн СТА-ын дүнгийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 290,395.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 248,755.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, 41,640.0 мянган төгрөгийн зөрчил, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан ЗДТГ-ын нягтлан бодогч Т.Отгонжаргалд хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүллээ. Үүнд:

Хүснэгт 11. ТЕЗ-ийн зөрчлийн нэгтгэл /мян.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгтгэсэн тайлан	2	1,640.0			2	1,640.0
2	СХС	1	248,755.0	1	248,755.0		
3	ОНХС	1	40,000.0			1	40,000.0
	ДҮН	4	290,395.0	1	248,755.0	3	41,640.0

Сумын ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,640.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 130 мэдээллээс 76 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, 40,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

3. Засаг дарга дансны болон орон нутгийн хөгжлийн сангийн шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан ЗДТГ-ын нягтлан бодогч Т.Отгонжаргалд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Сумын ерөнхийлөн захирагчид СХС-ийн 248,755.0 мянган авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тухайн байгууллагын хувьд балансын дараах үйл явцад хамааруулах асуудал гараагүй бөгөөд дараагийн аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргасан эсэхийг авч үзэх нь зүйтэй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон 248,755.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.
- 1.2. Эрсдэл: Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.
- 1.3. Өгсөн зөвлөмж Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН		
Бэлтгэсэн:	Аудитор	В.Цогжаргал
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер	Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор	Д.Уламбаяр